



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/222

Улаанбаатар хот

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн
тэргүүлэх чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 340 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарт 2023-2026 онд хэрэгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн тэргүүлэх чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Төр, хувийн хэвшлийн тэргүүлэх чиглэлд дурдсан үйл ажиллагааг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлтэй уялдуулан төлөвлөж, холбогдох санхүү, хөрөнгө оруулалтын тооцоо судалгааг гарган төсөвт тусган ажиллахыг Эрүүл мэндийн яамны газар, хэлтэс, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С. Төгсдэлгэр/-т даалгасугай.



САЙДС: *С. ЧИНЗОРИГ* С. ЧИНЗОРИГ

141223845



Эрүүл мэндийн салбарт 2023-2026 онд хэрэгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн тэргүүлэх чиглэл

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн нийгэмд шилжсэн үеэс Монгол Улсад хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага үүсэн байгуулагдсан. Өнөөгийн байдлаар 4500 гаруй хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаагийн 48 хувийг ортой хувийн эмнэлэг, клиник, 52 хувийг эм, хангамжийн байгууллага эзэлж байна.

Монгол Улсын Засгийн газар бүхий л үйлчилгээний салбарт хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг дэмжих, төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх бодлого хэрэгжүүлж байгаатай холбогдуулан 2023-2026 онд эрүүл мэндийн салбарт баримтлах төр, хувийн хэвшлийн түншлэлийн тэргүүлэх чиглэлийг “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль”, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” 340 дүгээр тогтоолд тусгагдсан зорилго, зорилт, арга хэмжээ болон тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан боловсруулах хэрэгцээ шаардлага бий болсон.

Тэргүүлэх чиглэлийн зорилго нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулан, иргэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах хүлээгдэл чирэгдлийг бууруулах, салбарын эдийн засгийн үр өгөөж, санхүүжилтийн механизмыг оновчтой болгоход оршино.

Тэргүүлэх чиглэлийг шинээр байгуулах хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл өөрчлөх, төрийн өмчит эрүүл мэндийн байгууллага хувийн хэвшлээр ажил, үйлчилгээ гэрээгээр гүйцэтгүүлэх, шилжүүлэх зэрэг үйл ажиллагаанд баримтлах чиглэл болгоно.

Тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтлана. Үүнд:

- Эрэлттэй тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах;
- Тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулж, ачааллыг тэнцвэржүүлэх;
- Иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах тэгш байдлыг хангах;
- Иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай хүргэх;
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн ил тод, нээлттэй байдлыг хангах.

Хоёр. Төр, хувийн хэвшлийн тэргүүлэх үйл ажиллагааны чиглэл

2. 1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр:

2.1.1 Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ;

- 2.1.2 Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйлчилгээ;
 - 2.1.3 Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа;
 - 2.1.4 Эрүүл мэндийн анхан шатны байгууллага, алслагдсан нутаг дэвсгэрт байрлах эрүүл мэндийн байгууллага болон сумын эрүүл мэндийн төвийн усан хангамж, ариун цэврийн байгууламж;
 - 2.1.5 Хөдөө орон нутагт эмнэлгийн хог хаягдлын үйлчилгээ.
- 2.2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чиглэлээр:
- 2.2.1 Урт хугацааны тусламж, үйлчилгээ:
 - Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ;
 - Сэргээн засах тусламж, үйлчилгээ*;
 - Сувилахуйн тусламж, үйлчилгээ*.
 - 2.2.2 Монгол Улсад оношлогдож эмчлэгдэхгүй байгаа өвчнийг оношлох, эмчлэх, эмчилгээний дараах тасралтгүй хяналтыг үргэлжлүүлэн хийх;
 - 2.2.3 Эмчилгээ, оношилгооны шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх;
 - 2.2.4 Алслагдсан бүс нутагт эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх өрхийн эрүүл мэндийн төв, шүдний эмнэлэг, эмийн сан байгуулах.
- 2.3. Эрүүл мэндийн салбарын удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:
- 2.3.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын хөндлөнгийн хяналт (тусламж, үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгаа, даатгуулагчийн сэтгэл ханамжийн судалгаа гэх мэт);
 - 2.3.2 Эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжлэл олгох, магадлан итгэмжлэлийн шинжээч бэлтгэх, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах, нөхөн олгох, хүчингүй болгох үйл ажиллагаа;
 - 2.3.3 Эрүүл мэндийн байгууллагын эрсдлийн үнэлгээ;
 - 2.3.4 Эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтны тасралтгүй сургалт;
 - 2.3.5 Эрүүл мэндийн байгууллагын хариуцлагын даатгалын үйлчилгээ.
- 2.4. Дэмжих үйлчилгээний чиглэлээр:
- 2.4.1 Эмнэлгийн багаж, материалын ариутгал, халдваргүйтгэл;
 - 2.4.2 Эрүүл мэндийн байгууллагын тусгай цэвэрлэгээ, үйлчилгээ;
 - 2.4.3 Эрүүл мэндийн байгууллагын тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ;
 - 2.4.4 Хэвтэн эмчлүүлэгчдэд зориулсан эмчилгээний хоол зүйн үйлчилгээ;
 - 2.4.5 Эрүүл мэндийн байгууллагын барилга, байгууламжийн засвар, үйлчилгээ;
 - 2.4.6 Харуул хамгаалалт.

* Орны тоог холбогдох тушаал шийдвэрээр хязгаарлалттай авч үзнэ.